

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код: 65.020.40

Мод, сөөгний үр тарих. Ерөнхий шаардлага	MNS 6253-2 : 2011
Planting seeds of trees. General requirement	

Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний Зөвлөлийн 2011 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 25 дугаар тогтоолоор батлав.

Энэ стандартыг улсын бүртгэлд бүртгэсэн өдрөөс эхлэн мөрдөнө.

1 Хамрах хүрээ

Энэхүү стандарт нь төрөл бүрийн мод, сөөгний үр тарих хэмжээ ба хугацаа, тарих аргад хамаарна.

2 Норматив ишлэл

Энэхүү стандартад дараах баримт бичгийг иш татсан бөгөөд эдгээр стандартад өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлчийн албан ёсны материалаас иш татаж хэрэглэнэ.

- MNS 2429 : 2009, Мод, сөөгний үр. Үрийн дээж авах арга,
- MNS 2887 : 2009, Мод, сөөгний үр. Үрийн соёололтыг тодорхойлох арга,
- MNS 5994 : 2009, Мод, сөөгний үр. Тариалалтын чанар. Техникийн шаардлага,
- ГОСТ 13204-91, Яст болон үрт үр жимст модны үр. Тариалалтын чанар. Техникийн шаардлага
- ГОСТ 13857-95, Мод, сөөгний үр.Тариалалтын чанар.Техникийн шаардлага
- ГОСТ 14161-86, Шилмүүст модны үр. Тариалалтын чанар.Техникийн шаардлага.

3 Нэр томъёо, тодорхойлолт

3.1

Туузлан тарих

Хоёр буюу түүнээс дээш хэд хэдэн ойрхон мөрийн дараа өргөн эгнээ хоорондын зай авч, дахин хэд хэдэн ойрхон мөрөөр тарихыг хэлнэ.

3.2

Үр тарих хэмжээ

Нэг метр урт мөрөнд тарих үрийн жин.

4 Ангилал

Үрийг жигд гүнд, нэгэн ижил зайтай мөрөөр тарина. Үүнд:

4.1 Өргөн мөрөөр эгнүүлэн тарих /мөр хоорондын зай 45 см/,

4.2 Нарийн мөрөөр эгнүүлэн тарих /мөр хоорондын зай 10-аас 20 см/,

4.3 Ердийн мөрөөр тарих /мөр хоорондын зай 25 см-аар/.

5 Техникийн шаардлага

5.1 Үр тарих хугацаа

5.1.1 Мод,сөөгний тарьц намрын цочир хүйтрэлтээс өмнө моджиж, өвлийн хүйтнийг тэсвэрлэх чадвартай торнисон байхаар үр тарих хугацааг тогтооно.

5.1.2 Намар тарих үрийг шууд тарихад байгалийн нөхцөлд өөрөө өвлийн турш тарилтанд бэлтгэгдээд, хавар эрт соёолж, үндэс нь түргэн хөгжиж, гадаад орчны нөхцөлийг тэсвэрлэх чадвартай болно.

5.2 Мод, сөөгний үр тарих хэмжээ

5.2.1 Үр тарих хэмжээг үрийн чанар, соёололт, ургах эрчим, цэвэршилт, мянган үрийн жин, мод үржүүлгийн газрын байгаль газар зүйн нөхцөл, ургуулах агротехникийн аргаас хамаарч ялгаатай тогтооно.

5.2.2 Мод, сөөгний үр тарих дундаж хэмжээ, хугацаа 1-р хүснэгтэд заасан хэмжээнд байна.

5.2.3 Үр тарих гүн нь тухайн ургамлын биологийн болон ургах орчны хөрс, цаг уурын онцлогоос шалтгаалан харилцан адилгүй байна. Том үрийг гүн, жижиг үрийг гүехэн тарихаас гадна бүтэц сайтай хөнгөн хөрсөнд үрийг гүн, хүнд хөрсөнд гүехэн, хуурай хөрсөнд чийг ихтэй талбайгаас гүн тарина.

Мод, сөөгний үр тарих хэмжээ, хугацаа

1-р хүснэгт

Д/д	Мод, сөөгний нэр	1000 үрийн дундаж жин (г)	1 метр урт мөрөнд тарих үрийн хэмжээ /г/		Үр тарих гүн /см/		Тарих хугацаа
			Ойн бүсэд	Ойт хээрийн бүсэд	Ойн ба хээрийн бүсэд	Хээрийн бүсэд	
	1	2	3	4	5	6	7
1	Гацуур	5,1	1,8	2,5	1,0-2,0	-	Хавар, намар
2	Жодоо	11,0	5,0	6,0	0,5-1,5	-	Хавар, намар
3	Нарс	5,6	1,5	1,5-2,0	0,5-1,4		Хавар, намар
4	Хуш	25,0	7,0	8,0	2,0-3,0	-	намар
5	Шинэс	7,0	3,0	4,0	0,5-1,5	1,5-2,0	хавар
6	Арц	11,0	2,0	3,0	1,5-2,0	2,0-3,0	намар
7	Майлаас	2,0	1,0	1,2	1,5-2,0	2,0-2,5	Хавар, намар
8	Хайлаас	3,9	0,5-1,0	1,1-1,5	1,5-2,0	2,0-2,5	6-р сард
9	Чацаргана	13,0	3,0	3,5	1,5-2,0	2,0-2,5	Хавар, намар
10	Нохойн хошуу	12,0	2,0	2,5	1,5-2,0	2,0-2,5	намар
11	Тэс	3,6	1,8	2,0	1,5-2,0	2,0-2,5	намар
12	Монос	65,0	6,0	7,0	2,0-2,5	2,5-3,0	намар
13	Шар хуайс	25,0	3,5	4,0	2,0-2,5	2,5-3,0	Хавар, намар
14	Гүйлс	530,5	38,0	40,0	2,5-3,0	3,0-4,0	Хавар, намар
15	Буйлс	259,4	20,0	25,0	2,0-2,5	2,5-3,0	Хавар, намар
16	Өрөл	4,0	0,5-1,0	1,5-2,0	1,5-2,0	2,0-2,5	Хавар, намар
17	Хус	0,2	0,1	0,15	0,5-1,0	1,0-1,2	6 сард

18	Долоогоно	26,0	9,0	11,0	2,0-2,5	3,0-3,5	намар
19	Муркрофтын жигд	167,5	80,0	100,0	2,5-3,0	3,0-4,0	намар
20	Далан хальс	2,6	0,5	1,0	0,5-1,0	1,0-1,5	Хавар, намар
21	Тэсмэг	0,35	0,15	0,2	0,1-0,2	0,2-0,3	Хавар, намар
22	Чаргай	12,4	3,5	4,0	2,0-2,5	2,5-3,0	намар
23	Үхрийн нүд	2,0	0,5	1,0	0,2-0,3	0,4-0,5	хавар
24	Тошлой	1,8	0,5	1,0	0,2-0,3	0,4-0,5	хавар
25	Голтбор	7,7	1,5	2,0	1,5-2,0	2,0-2,5	Хавар, намар
26	Тавилгана	0,26	0,1	0,15	0,1-0,2	0,2-0,3	Хавар
27	Гандигар	2,4	0,5	1,0	0,5-1,0	1,0-1,5	Хавар, намар
28	Агч	34,5	5,0	6,0	2,0	2,5-3,0	хавар
29	Харгана	18,0	2,5	3,0	1,5-2,0	2,0-2,5	хавар
30	Яргай	26,0	3,0	4,0	1,5-2,0	2,0-3,0	намар
31	Яшил	22,0	3,0	2,5	1,5-2,0	2,0-2,5	намар
32	Тэхийн шээг	3,2	0,5	1,0	0,5-1,0	1,0-1,5	хавар
33	Мөнгөлөг жигд	90,0	15,0	20,0	1,5-2,0	2,0-3,0	Хавар, намар
34	Шар мод	10,0	1,5	2,0	1,0-1,5	1,5-2,0	Хавар, намар
35	Тэрэлж	0,4	0,2	0,25	0,1-0,2	0,2-0,3	Хавар, намар


ТАЙЛБАР 1: Үрийн хэмжээг MNS 5994 : 2009 үрийн чанарын зэргийн стандартад заасны дагуу шилмүүст модны 2-зэрэгт 30%, 3-зэрэгт 100%, хуснаас бусад навчит модны 2-зэрэгт 20%, 3-зэрэгт 60%, хусны 2-зэрэгт 50%, 3-зэрэгт 100% тус тус нэмэгдүүлэн тарина.

ТАЙЛБАР 2: Үрийг намар тарихдаа нохойн хошууны үрийг 8-р сард гүйцэд боловсроогүй үед хурааж аваад шууд тарина. Чаргай, долоогоно, монос, бариулт бүйлсны үрийг 9-ээс 10-р сард буюу газар хөлдөхөөс өмнө тарина.

5.3.1 Мод, сөөгний үрийг тарихын өмнө хөрсийг MNS 6263 : 2011 стандартын дагуу боловсруулан, талбайг тэгшлэн хөрсийг сайжруулсан байна.

5.3.2 Үр тарилтын хэмжээг нарийн мөрдөж бүх талбайд жигд тарьсан байвал зохино.

5.3.3 Мод, сөөгний үрийг эгнээ хооронд 60-аас 70 см-ийн зайтай эгнүүлэн тарих эсвэл зэрэгцээ 2 мөрний хооронд 35-аас 45 см, хос мөрний хооронд 10-аас 20 см зайтайгаар туузлан тарина.




1-р зураг. Үр тарих арга

- I- Өргөн мөрөөр эгнүүлэн тарих
- II- 2 мөрөөр эгнүүлэн тарих
- III- 4 мөрөөр эгнүүлэн тарих
- IV- 4 мөрөөр туузлан тарих
- V- 6 мөрөөр туузлан тарих
- VI- 2 мөрөөр туузлан тарих

5.3.4 Үр тарих даланг чийгтэй хөрсөнд газраас 10-аас 15 см дээш, чийг багатай хөрсөнд газраас 5-аас 7 см доор 0,9-өөс 1,2 м өргөн байгуулна. Далангийн хооронд 30-аас 40 см зайтай байна.

5.3.5 Гараар тарихдаа талбайд 5.3.4-т заасан хэмжээ тавьж, түүнийхээ дагуу зориуд бэлтгэсэн ховил гаргагчаар тарих мөрөө шаардагдах өргөн, гүнтэйгээр гарган, үрээ тарина /2-р зураг/.



2-р зураг - Үр тарих гар ажиллагаа

5.3.6 Үрийг тарьсны дараа сэвсгэр шороо, модны үртсээр 1,5-аас 2,0 см хүртэл булна.

ТӨГСӨВ.